БАТЛАВ
БАЯНЗҮРХ ЭКО ТОХИЖИЛТ, ҮЙЛЧИЛГЭЭ
ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ Ж.БАТБОЛД

ОЧҮ0127 9022010658 6014855

Мод суулгацын техникийн тодорхойлолт

Зорилго:

Баянзүрх дүүргийн 11 дүгээр хороо “Хонхор нуур”-т байрлах мод үржүүлгийн талбайд таригдана.

Нийлүүлэгчид тавигдах шаардлага:

1. Тендерт оролцогч нь мод үржүүлгийн газрын тусгай зөвшөөрөлтэй байх
2. Монгол улсын цаг уурт зохицон ургасан, нутагшсан суулгац байх
3. Мод үржүүлгийн талбайгаас нь авсан байх, тээвэрлэлтэд зориулж үндсийг нь гэмтээхгүйгээр битүүмжилж өөрийн чийгтэй хөрсөнд боож багласан байх шаардлагатай.

**MNS 6141 : 2010**

**Навчит төрлийн модны суулгацад тавих шаардлага**

| д/д | Үзүүлэлт | Хэмжээ шаардлага |
|---|---|---|
| 1 | Гадаад байдал | Гадна талын байдал өнгө хэвийн,холтос нь шалбарч гэмтээгүй, өвчин хөнөөлт шавжид нэрвэгдээгүй, нахиа задраагүй, уян зөөлөн мөчиртэй, иш нь бүдүүвтэр, эгц шулуун, бат бөх үндэс ихтэй өсөлт сайтай байна. |
| 2 | Хэлбэр | Зөв титэмтэй, мөчир нь хугараагүй, салаалсан мөчрүүдтэй байна. |
| 3 | Хэмжээ:<br>➢ Үндсэн мөчрийн тоо<br>➢ Титмийн тэлэлтийн гол /метр/<br>➢ Суулгацын өндөр /метр/<br>Улиас<br>Хайлаас | 8-10<br>1,0-1,5<br><br><br>1,2-1,5<br>0,8-аас дээш |
| 4 | Үндэс | Өсөлт сайтай, 3-аас доошгүй бүдүүн үндэстэй, салаалсан үндэс ихтэй байх ба үндсийг үржил шимтэй шороотой нь хамт авна. Шорооны чийгийг алдагдуулж болохгүй. |
| 5 | Суулгацыг хүлээн авах | Гарал үүслийн бичигтэй байна. Суулгацыг хүлээн авах,суулгахдаа агротехникийн шаардлагыг баримтална. /Мод үржүүлгийн талбай болон ойгоос суулгацыг авахдаа урд зүг буюу нар харсан талд нь тэмдэг тавьсан байх./ |

**MNS 6139 : 2010**

**Шилмүүст төрлийн модны суулгацад тавих шаардлага**

| д/д | Үзүүлэлт | Хэмжээ шаардлага |
|---|---|---|
| 1 | Гадаад байдал | Гадна талын байдал өнгө хэвийн, холтос нь шалбарч гэмтээгүй, өвчин хөнөөлт шавжид нэрвэгдээгүй, нахиа задраагүй, уян зөөлөн мөчиртэй, иш нь бүдүүвтэр, эгц шулуун, бат бөх үндэс ихтэй өсөлт сайтай байна. |
| 2 | Хэлбэр | Зөв титэмтэй, мөчир нь хугараагүй, салаалсан мөчрүүд нь ишний нийт уртын ¾ - ийг эзэлсэн байна. |
| 3 | Хэмжээ:<br>а.үндсэн мөчрийн тоо<br>б.титмийн тэлэлтийн гол / метр/<br>в.суулгацын өндөр /метр/<br>Нарс<br>Гацуур | <br>10-15<br>1,2-1,5<br><br>1,5-аас дээш<br>1,5-аас дээш |
| 4 | Үндэс:<br><br><br>а. Үндэстэй хамт авсан шороотой хэсгийн голч метрээр<br>б.Үндэстэй хамт авсан шороотой хэсгийн зузаан метрээр | Өсөлт сайтай, 3-аас доошгүй бүдүүн үндэстэй, салаалсан үндэс ихтэй байх ба үндсийг үржил шимтэй шороотой нь хамт авна. Шорооны чийгийг алдагдуулж болохгүй.<br>1,0-1,2<br><br>0,6-0,7 |
| 5 | Суулгацыг хүлээн авах | Гарал үүслийн бичигтэй байна. Суулгацыг хүлээн авах,суулгахдаа агротехникийн шаардлагыг баримтална. /Мод үржүүлгийн талбай болон ойгоос суулгацыг авахдаа урд зүг буюу нар харсан талд нь тэмдэг тавьсан байх/ |

**MNS 6141 : 2010**

**Сөөгөнцөр төрлийн модны суулгацад тавих шаардлага**

| д/д | Үзүүлэлт | Хэмжээ шаардлага |
|---|---|---|
| 1 | Гадаад байдал | Гадна талын өнгө байдал хэвийн, шалбарч гэмтээгүй, өвчин хөнөөлт шавжид нэрвэгдээгүй, нахиа нь хугацаанаасаа эрт задраагүй, мөчир, үндэс ихтэй, гувар нь эгц шулуун бат бэх, хугараагүй, өсөлт хөгжилт сайтай байна. |
| 2 | Хэлбэр | Титэм зөв хэлбэртэй байна. |
| 3 | Хэмжээ:<br>а.Сөөгний өндөр, метр<br>б.Үндсэн мөчрийн тоо | <br>0,8-1,2<br>6-8 |
| 4 | Үндэс: | Өсөлт сайтай, 3-аас доошгүй бүдүүн үндэстэй, салаалсан үндэс ихтэй байх ба үндсийг үржил шимтэй шороотой нь хамт авна. Шорооны чийгийг алдагдуулж болохгүй. |

| | | |
|---|---|---|
| | а. Үндэстэй хамт авсан үржил шимтэй шороотой хэсгийн голч /см/<br>б.Үндэстэй хамт авсан үржил шимтэй шороотой хэсгийн зузаан /см/ | 20-35<br><br>15-30 |
| 5 | Суулгацыг хүлээн авах | Гарал үүслийн бичигтэй байна. Суулгацыг хүлээн авах,суулгахдаа агротехникийн шаардлагыг баримтална. /Мод үржүүлгийн талбай болон ойгоос суулгац/-ыг авахдаа урд зүг буюу нар харсан талд нь тэмдэг тавьсан байх. |

ХЯНАСАН:
НОГООН БАЙГУУЛАМЖИЙН
АЛБАНЫ ДАРГА Д.БАТЦЭЦЭГ

БОЛОВСРУУЛСАН:
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ
МЭРГЭЖИЛТЭН М.АРИУНЖАРГАЛ